



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/753

Номгон

Эзэмшил газрын талбайн хэмжээ залруулах  
тухай

Монгол Улсын "Газрын тухай хууль"-ийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33.1.1 дэхь заалт, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эзэмшил газрын хэмжээ зөрөөтэй байгаа Төрийн байгууллагуудын эзэмшил газрын хэмжээг хавсралтаар батласны дагуу залруулж 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.
2. Эзэмшил газрын талбайн хэмжээ өөрчлөгдсөн байгууллагуудын газрыг бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /Т.Норов/-т үүрэг болгосугай.
3. Эзэмшил газрын 10 хувийг цэцэрлэгжүүлэн зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг хавсралтаар батлагдсан газар эзэмшигч байгууллагуудад үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Д.Ихбаяр/-т даалгасугай.

ДАРГА



Г.БАТЖАРГАЛ

1181600

D:\2018 он\Захирамж-2018 он.docx



Аймгийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 16-ны  
өдрийн А/753 дугаар захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУГАЦАА СУНГУУЛЖ  
БАЙГАА БАЙГУУЛЛАГЫН НЭР

д/д	Газар эзэмшигчийн нэр	Регистрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Зориулалт	Байршил	Талбайн хэмжээ /м2/	Заглуулагдаж буй талбайн хэмжээ /м2/	Эзэмших эрхийн хугацаа
1	Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Эрдэм ахлах сургууль	3124282	-	Боловсролын байгууллага	Баянхонгор сум, Дуурсах 3-р баг	12693,1 м2	14730 м2	15 жил
2	Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс	9007512	-	Албан контор	Баянхонгор сум, Номгон 1-р баг	2464 м2	2689 м2	15 жил
3	Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Номуун далай цогцолбор сургууль	9007652	-	Дотуур байрны	Баянхонгор сум, Номгон 1-р баг	1521,8 м2	1541 м2	15 жил
4	Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Номгон ахлах сургууль	9007679	-	Боловсролын байгууллага	Баянхонгор сум, Номгон 1-р баг	33361 м2	32503 м2	15 жил
5	Баянхонгор аймгийн Баянхонгор сумын сургууль, Цэцэрлэгийн Баян-ойт цогцолбор	9007695	-	Боловсролын байгууллага	Баянхонгор сум, Номгон 1-р баг	5213 м2	5659 м2	15 жил